



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ-д
Нэхэмжлэл гаргах нь:

2024.00.00

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: **Хүүхдийн эцэг болон хамтын амьдралтай байсныг тогтоолгох тухай**

Б.Дулмаа миний бие Б.Төмөртэй 0000 оны 00 сарын өдөр танилцаж, 0000 оны намраас хамтран амьдарч эхэлсэн. Бидний хүү Д.Ган 0000 оны 00 сарын 00-ны өдөр төрсөн. Хүү төрөх үед нөхөр Б.Төмөр Өмнөговь аймаг дахь Оюу толгой дахь уурхайн гэрээт харуул хамгаалалтын компанид харуул хамгаалалтын ажилтанаар ажиллаж байсан бөгөөд 3 сарын турш хөдөө ажиллаад амардаг үе нь таарсан тул хүүхдийн төрсний гэрчилгээг би өөрийн нэрээр авсан.

Бид гэрлэлтээ бүртгүүлээгүй ч 5 жил гаруй Баянгол дүүргийн 00-р хороо, Зүүн Ард Аюушын 00-000 тоотод хамтран амьдарсан. Гэтэл 0000 оны 00 сарын 00-ны өдөр нөхөр Б.Төмөр гэнэт нас барсан. Шүүх эмнэлэгээс зүрхний шигдээс гэдэг дүгнэлт гаргасан.

Одоо хүү Д.Ганд тэжээгчээ алдсаны тэтгэмж тогтоолгох гэтэл гэрлэлтийн бүртгэлгүй, хүүхэд эцгээрээ овоглоогүй шалтгаанаар тэтгэмж олдохгүй байдалд хүрээд байна. Миний бие холбогдох баримтыг бүрдүүлэн хүү Д.Гангийн эцгийг болон Б.Төмөртэй хамтран амьдарч байсан байдлыг тогтоолгохоор нэхэмжлэл гаргаж байна.

Иймд 0000 оны 00 сарын 00 өдөр төрсөн, 3 настай хүү, Д.Гангийн эцэг Б.Төмөр мөн болохыг, 0000 оны 00 сарын 00-ны өдрөөс 0000 оны 00 сарын 00-өдрийн хүртэл бидний хамтран амьдарч байсан байдлыг тус тус тогтоож өгнө үү.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтууд:

- 1.Нэхэмжлэл 1 хувь /1 хуудас/
 - 2.Миний иргэний үнэмлэхийн хуулбар
 - 3.Миний оршин суугаа хорооны Засаг даргын тодорхойлолт
 - 4.Хүү Н.Г-ийн төрсний гэрчилгээний хуулбар
 - 5.Хүү Н.Г эрүүл өсч бойжиж байгаа Эрдэнэт хүн ӨЭМТ-ийн эмнэлэгийн магадлагаа
 - 6.Талийгаач нөхөр Б.Төмөрийн нас барсны бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - 7.Талийгаач нөхөр Б.Төмөрийн төрсөн ах Б.А, төрсөн дүү Б.Н нарын иргэний үнэмлэхийн хуулбар
 8. Талийгаач нөхөр Б.Төмөрийн төрсөн ах Б.А., төрсөн дүү Б.Н нарын гэрчийн мэдүүлэг, нотариатчаар гэрчлүүлсэн
 - 9.Улсын тэмдэгтийн хураамж 70.200 төгрөг төлсөн баримт, нийт 11 хуудас
- Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Gegece системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.

Нэхэмжлэл гаргасан:

Нэр ... гарын үсэг ... гарын үсгийн тайлал